



## ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 05 сарын 30 өдөр

Дугаар 285

Улаанбаатар хот

### Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг сунгах, үнийг шинэчлэн тогтоох, балансаас балансад шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 2, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсгийн 2 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1, 7.1, 7.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Сүлд биеийн тамир, спортын хорооны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 2 нэрийн, нийт 2,500,800.00 (хоёр сая таван зуун мянга найман зуун) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, үнийг 1,250,400.00 (нэг сая хоёр зуун тавин мянга дөрвөн зуун) төгрөгөөр шинэчлэн тогтоож, 1 дүгээр хавсралтад заасны дагуу Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх албанд балансаас балансад шилжүүлсүгэй.

2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Сүлд биеийн тамир, спортын хорооны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 17 нэрийн нийт 33,151,270.00 (гучин гурван сая нэг зуун тавин нэгэн мянга хоёр зуун далан) төгрөгийн балансын үнэ, 6,691,349.58 (зургаан сая зургаан зуун ерэн нэгэн мянга гурван зуун дөчин есөн төгрөг тавин найман мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийг 2 дугаар хавсралтад заасны дагуу Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх албанд балансаас балансад шилжүүлсүгэй.

3. Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Сайнзориг, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дарга, хурандаа О.Амарсанаа болон тогтоолд заасан байгууллагын дарга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

3.1. Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

3.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

3.3. Арга хэмжээний биелэлтийг 2023 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

4.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА  Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2023 оны 5 дугаар сарын 24 ны өдрийн  
28 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

"СҮЛД" БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ХОРООНЫ ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, АШИГЛАЛТЫН ХУГАЦААГ СУНГАХ,  
ШИНЭЧЛЭН ТОГТООЖ, ХОРИХООС ӨӨР ТӨРЛИЙН ЯЛ ЭДЛҮҮЛЭХ АЛБАНД БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ  
ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Үндсэн хөрөнгийн нэр	Хэм жиж нэгж	Тоо хэм жээ	Ашиглалтад орсон он	Нэг бүрийн үнэ	Балансын үнэ, хуриимтлагдсан элэгдэл (төгрөг)	Шинэчлэн тогтсоон үнэ (төгрөг)			
							Цаашид ашиглах хугацаа	Тоо шир хэг	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Нийт үнэ (төгрөг)
1	Чихэвч /студи/	ш	1	2020	521,000.00	521,000.00	5	1	260,500.00	260,500.00
2	Яригч /студи/	ш	2	2020	989,900.00	1,979,800.00	5	2	494,950.00	989,900.00
	Нийт дүн					2,500,800.00				1,250,400.00

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
 2023 оны ... дугаар сарын ... ны өдрийн  
 ... дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

"СҮЛД" БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ХОРООНЫ ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭИ, ХОРИХООС ӨӨР ТӨРЛИЙН  
 ЯЛ ЭДЛҮҮЛЭХ АЛБАНД ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСГААЛТ

Д/д	Үндсэн хөрөнгийн нэр, марк	Хэм жих нэгж	Тоо хэм жээ	Ашиглалтад орсон огноо	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Балансын нийт үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)
1	Аудио бичигч	ш	1	2020	801,270.00	801,270.00	550,873.29	250,396.71
2	Олон замаар бичигч /allen&Heath/	ш	1	2021	14,124,100.00	14,124,100.00	2,522,160.75	11,601,939.25
3	Шүүлтгийн яригч /студи/	ш	2	2021	3,200,000.00	6,400,000.00	1,142,857.20	5,257,142.80
4	Микрофон /студи/	ш	1	2021	665,000.00	665,000.00	118,750.05	546,249.95
5	Микрофоны зурвас өргөтгөгч /2 оролттой/	ш	1	2021	1,251,000.00	1,251,000.00	223,392.90	1,027,607.10
6	Тоон систем салаалагч /Allen&Heath GLD-AR24/	ш	1	2021	4,350,000.00	4,350,000.00	776,785.65	3,573,214.35
7	Чихэвч салаалагч /HA8000/	ш	1	2021	680,000.00	680,000.00	121,428.60	558,571.40
8	Холбогч кабель /pro snake/	ш	1	2021	750,000.00	750,000.00	133,928.55	616,071.45
9	Суурин процессор	ш	1	2021	1,600,000.00	1,600,000.00	285,714.30	1,314,285.70
10	Микрофоны хөл	ш	1	2021	179,900.00	179,900.00	32,125.05	147,774.95
11	Ёочин	ш	1	2021	350,000.00	350,000.00	116,666.64	233,333.36
12	Ёочин /жижиг/	ш	1	2021	300,000.00	300,000.00	99,999.96	200,000.04
13	Хуучир /жижиг/	ш	1	2021	200,000.00	200,000.00	66,666.72	133,333.28
14	Шанз	ш	2	2021	300,000.00	600,000.00	200,000.04	399,999.96
15	Ятга	ш	1	2021	350,000.00	350,000.00	116,666.64	233,333.36

16	Морин хуур-1		ш	1	2021	300,000.00	300,000.00	99,999.96	200,000.04
17	Морин хуур-2		ш	1	2021	250,000.00	250,000.00	83,333.28	166,666.72
	Нийт дүн						33,151,270.00	6,691,349.58	26,459,920.42